



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

додо оны *10* сарын *10* өдөр

Дугаар *111339*

Улаанбаатар хот

**Н.Бадрахцогт сахилгын
шийтгэл ногдуулах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 4.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2018 оны А/211 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Норжмаагийн Бадрахцог нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.6 дахь хэсэг “Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 12.2, 12.3-т зааснаас бусад мэдээллийг тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр, ... өгөх бөгөөд ... тогтооно”, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4.7 дахь заалт “улсын бүртгэлийн талаарх мэдээлэл лавлагааг иргэн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу гаргаж өгөх” гэж заасныг зөрчин бусдын өмчлөлд байгаа үл хөдлөх эд хөрөнгийн лавлагааг өөр иргэнд өгч хуулиар хүлээсэн албан үүрэгтээ хариуцлагагүй хандсан нь тогтоогдсон тул түүнд 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилтоо хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Бадрахцогт үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Сонгинохайрхан дүүрэг дэх Улсын бүртгэлийн хэлтэс /Т.Булгантамир/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвэл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Д.ДЭЛГЭРСАЙХАН

571004609